



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

138 /138/

2021.09.20

ӨНӨӨДӨР ШҮХЭРЧИН ДАЙЧДЫН ӨДӨР ТОХИОЖ БАЙНА.

ШҮХЭРЧИН ДАЙЧИДДАА БАЯРЫН МЭНД ДЭВШҮҮЛЬЕ!

Тэнгэр нь цэлмэг, газар нь зөөлөн байг!



ҮЙЛ ЯВДАЛ

“ЦЭРГИЙН СУРГАЛТ БЭЛТГЭЛИЙН ОРЧНЫ ШИНЭЧЛЭЛ БА ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ” СЭДВИЙН ДОР ЦУГЛАРАВ

Жил бүр зохион байгуулагддаг Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний заах арга зүйн цуглалт энэ сарын 17-19-ний өдрүүдэд болж өнгөрлөө.

Энэ удаагийн цуглалт “Цэргийн сургалт бэлтгэлийн орчны шинэчлэл ба дэвшилтэт технологи” сэдвийн дор өрнөлөө. Ингэхдээ түвшин тогтоох үзлэг, үзүүлэх сургууль, онол арга зүйн сургалт, цэргийн сургалт бэлтгэлийн үр дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ гэсэн үндсэн гурван үе шаттай явагдсан. Цуглалтын зорилго нь Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын бие бүрэлдэхүүний онолын мэдлэг, дадлагыг нэмэгдүүлэх, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, төрөөс баримталж байгаа бодлого, Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийг зохион байгуулах талаар харилцан туршлага солилцож нэгдсэн ойлголтод хүрэхэд чиглэгджээ.

Цуглалтын эхний өдөр Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвд Тусгай хүчний цэргийн командлагч, бригадын генерал Б.Баатар Ротын байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийг удирдан явууллаа. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүхийн баримталж буй бодлогын талаар Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, Батлан хамгаалах бодлогын зөвлөх, дэслэгч генерал Ц.Тогоо илтгэл, мэдээлэл хүргэсэн.

Батлан хамгаалах салбарын шинжлэх ухаан, технологийн шинэчлэлийн талаар хэрэгжүүлж буй бодлого, дэвшилтэт технологи ба зайн сургалт, Зэвсэгт хүчний болон орон нутгийн цэргийн сургалт бэлтгэлийн уялдаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх зэрэг сэдвийн хүрээнд цуглалт амжилттай явагдлаа.



ЛРГЭЛЖЛЭЛ НЬ АРЫН НҮҮРТ/

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 247,212 +3234	ЭДГЭРСЭН 241,501 +4767	НАС БАРСАН 1042 +8
--	----------------------------------	------------------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 5026 +85	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 194	ЭДГЭРСЭН 4737
------------------------------------	-----------------------------------	-------------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 229,262,049
Эдгэрсэн Нийт: 205,880,669
Нас барсан Нийт: 4,705,033

Түүхэнд энэ өдөр

1929 он:

Энэ өдөр МАХЦ-т анхны морьт дивизийг байгуулав.

1944 он:

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 72 дугаар хурлын тогтоолоор “Ард нийтээс цэргийн алба хаах хууль”-ийг баталжээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 18	☁️ 2

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 31	☁️ 22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2,844.00	2,855.00
EUR 🇪🇺	3,339.0	3,393.0
CNY 🇨🇳	440.80	445.20
RUB 🇷🇺	38.80	40.50
JPY 🇯🇵	25.76	26.26
KRW 🇰🇷	2.36	2.49

ЗУРХАЙ

2021.09.20 ДАВАА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 15/

НАМРЫН ДУНД УЛААГЧИН ТАХИА САРЫН ЗУРГААН ЦАГААН ЦАГААЧИН ХОНЬ ӨДӨР

Үс засуулбал:

Өлзийтэй сайн

Наран ургах, шингих:

06.36-18.55

Барилдлага:

Үхэх

Шүтэн барилдлага:

Төрөхүй

Суудал:

Хий

Өнөөдөр аргын тооллын 2021 оны 9 дүгээр сарын 20. Даваа гараг. Билгийн тооллын XVII Жарны “Цөөвөр” хэмээх Цагаагчин төмөр үхэр жилийн Намрын дунд улаагчин тахиа сарын шинийн 15. Сумъяа гараг. Шувуун хошуут одтой, зургаан цагаан мэнгэтэй, цагаагчин хонь өдөр.

Өдрийн наран 6 цаг 36 минутад мандан, 18 цаг 55 минутад жаргана. Тухайн өдөр гахай, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд зөрөг сайн. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал адуус муулах, угаал үйлдэх, мал худалдан авах, мал түгээх, хийморийн ддарцааг хатагахад сайн.

Сахил санваар авах, хануур төвнүүр хийлгэх, уул овоо тахирад муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал өлзийтэй сайн хэмээжээ.



ЦАХИМ ШУУДАН

ШИЛЖИН ЯВАХ АВАРГЫН ЦОМОО ГАРДЛАА



Зэвсэгт хүчний 350 анги
Монголын үндэсний олон нийтийн телевизийн "Монголын мэдээ" сувгийн "Явлаа, ирлээ" нэвтрүүлэгт ажиллагааны ахлах офицер ахмад Б.Цээноров оролцож Оросын Холбооны Улсад зохион байгуулагдсан "Олон улсын цэргийн наадам"-ын "Аравт" олон улсын морин цэргийн уралдаанд хэрхэн оролцсон талаараа ярилцлаа.

Түүнчлэн Зэвсэгт хүчний "Цэрэгжлийн гимнастик"-ийн олон төрөлт, чөлөөт хөдөлгөөний төрөлд ахлагч О.Хонгор II байрт шалгарч мөнгөн медаль хүртсэн бол олон төрөлтийн нийлбэр дүнгээр ахлагч Д.Бүрэнтогтох II мөнгө, сонс эргэлтийн төрөлд ахлагч Т.Гантогтох 419 удаа эргэж алт, ахлагч Б.Балжинням 279 эргэж хүрэл медаль хүртдээ. Эрэгтэй баг

тамирчид багийн нийлбэр дүнгээр IV байр, эмэгтэй баг тамирчид нийлбэр дүнгээр I байрт шалгарч шилжин явах аваргын цом хүртлээ.

Мөн цэрэгжлийн спортын I зэргээр ахлах ахлагч Б.Банзрагч, ахлагч Т.Гатогтох, ахлагч Б.Төгсбаяр, II зэргээр ахлагч О.Хонгор нар шагнагдлаа.

Ахмад Б.ДЭРДЭНЭНИНЖ



ОН ДУУСАХАД 102 ӨДӨР ҮЛДЛЭЭ...

Өнөөдөр 2019.09.20. Энэ оны 263 дахь өдөр. Он дуусахад 102 өдөр үлдээд байна.

Өнөөдөр Балбад Үндсэн хуулийн өдөр, Тайландад Үндэсний залуусын өдөр, Германд Хүүхдийн өдөр тохиож байна.

Энэ өдөр мэндэлсэн алдартнуудаас дурдвал, Италийн жүжигчин Софи Лорен, Америкийн кино зохиолч, продюсер Жорж Мартин, Францын жүжигчин Сабина Азема, Гондурасын Ерөнхийлөгч асан Мануэл Селайя, Америкийн жүжигчин

Гэри Коул, Оросын дуучин Андрей Державин, Шведийн хөлбөмбөгч Хенрик Ларссон, Оросын холимог тулаанч, UFC-гийн аварга Хабиб Нурмагомедов, Канадын хоккейч Жон Таварес нар юм.

Энэ өдөр Монгол Улсын түүхэнд болсон онцлох үйл явдлуудаас дурдвал:

1929 оны энэ өдөр БНМАУ-ын 14 дүгээр Бага хурал хуралджээ.

1944 оны энэ өдөр Ард нийтийн цэргийн алба хаах үүргийн тухай хууль батлагдав.

1960 оны энэ өдөр Монгол, Хятадын Засгийн газрын төлөөлөгчид Улаанбаатар хотноо

"БНМАУ-д тусламжаар барилга барих БНХАУ-ын барилгын ажилчдын тухай хэлэлцээр"-т гарын үсэг зуржээ.

Энэ өдөр дэлхий дахинд болсон онцлох үйл явдлуудаас дурдвал:

1990 оны энэ өдөр Өмнөд Осет Гүржээс тусгаар улс болжээ.

1992 оны энэ өдөр Францын иргэдийн дийлэнх нь бүх нийтийн санал хураалтаар улсаа Европын холбоонд оруулахыг дэмжив.

1993 оны энэ өдөр Азербайжаны парламент Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлд орохыг дэмжжээ.

Үйл явдал

"ЦЭРГИЙН СУРГАЛТ БЭЛТГЭЛИЙН ОРЧНЫ ШИНЭЧЛЭЛ БА ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ" СЭДВИЙН ДОР ЦУГЛАРАВ

ГҮРҮҮЧ НЬ ЭХНИЙ НҮҮРТ

Цугларалтын төгсгөлд ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг удирдах бүрэлдэхүүнд хандан үүрэг, чиглэл өгсөн. Тэр бээр хэлэхдээ "Зэвсэгт хүчний офицерын боловсрол, цэргийн хэргийн мэдлэг, чадвар, цэргийг сургаж хүмүүжүүлэх, удирдах чадвар, ажлын арга барил, хариуцлагаас Зэвсэгт хүчний өмнө тавигдсан зорилго зорилт, үүргийн хэрэгжилт, амжилт шууд хамаарна. Тийм учраас цэргийн сургалт бэлтгэл, сэлтгэл зүйн хангалтыг гардан зохион байгуулагч бүх шатны удирдлагууд гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчидтай ажиллаж байгаа залуу офицеруудын хүнтэй ажиллах арга барилыг сайжруулах, өөрийгөө хөгжүүлэх, цэргийн сургалт бэлтгэлийг зохион байгуулж явуулах арга зүйд сурган дадлагуулах нь чухал ач холбогдолтой. Нөгөөтэйгөөр Зэвсэгт хүчний удирдлагад байгаа та бүхэн цаг, минутаар хувьсан өөрчлөгдөж байгаа нийгэмтэйгээ хөл нийлүүлэн алхахын тулд өөрийгөө байнга боловсруулж, хөгжүүлж байх нь чухал болоод байна" гэж хэлсэн юм.



Дараа нь ЗХЖШ-ын Сургалтын бодлого зохицуулалтын хэлтсээс цахим сургалт явуулах иж бүрэн төхөөрөмжийг зарим ангид гардуулан

өгсөн. Түүнчлэн Зэвсэгт хүчний аварга шалгаруулах туухай өргөлтийн тэмцээнд бусдыгаа хошуучилсан тамирчдын цом, медалийг ангийн удирдлагуудад нь гардууллаа.

ЦЭРЭГЖЛИЙН СПОРТЫН ТЭМЦЭЭНИЙГ ӨНГӨЛЛӨӨ

Зэвсэгт хүчний 065 дугаар анги

Зэвсэгт хүчний 2021 оны аварга шалгаруулах цэргийн 3 төрөлт, цэрэгжлийн буудлага, туухай өргөлт, цэрэг спортын цогцолборын зуны олон төрөлт, саадын зурвасын тэмцээний нээлт Хужирбулан дахь сургалтын төвд боллоо. Тэмцээнийг цар тахлаас урьдчилан сэргийлж, халдвар хамгааллын дэглэмийг хатуу чанд сахин зохион байгуулж байна. Энэ удаагийн тэмцээнээр тус ангийн тамирчид хурд, хүч, авхаалж самбаагаа сорьж дараах амжилтыг үзүүлээ. Үүнд, цэрэгжлийн буудлага гар буу тогтоолын төрөлд хошууч Д.Эрдэнэбулган мөнгө, цэргийн гурван төрөлтийн аварга шалгаруулах гүйлтийн төрөлд дэд ахлагч Э.Эрэмгийбаатар хүрэл, саадын зурвасын төрөлд дэд ахлагч М.Ариунтуяа алт, саадын зурвасын буухиа төрөлд ахмад Ц.Одгэрэл, дэд ахлагч М.Ариунтуяа нар алтан медаль хүртэж, саадын



зурвасын эмэгтэйчүүдийн төрөлд нийлбэр дүнгээр цомын эзэд боллоо. Цэрэгжлийн гимнастикийн аварга шалгаруулах ахлагч Рэгээдмаа, дэд ахлагч С.Бадамгэрэл нар мөнгөн медаль тус тус

хүртсэн амжилттайгаар тэмцээнээ үргэлжлүүлж байна. Ангийнхаа нэрийг Зэвсэгт хүчний хэмжээнд алдаршуулсан нийт тамирчиддаа халуун баяр хүргэе.

Ахмад Ө.ЭНХСАРУУЛ

Б.Мөнхбаяр
Хүүдээ амьдрал бэлэглэе.

Утас: 9904.4415

ХАНДИВЫН АЯН

ХАНДИВЫН ДАНС

Аав ээний алдрай хүү Б.Мөнхбаяр нь 2020 онд гэр бүлдээ баяр байсгалан бэлэглэж мэндэлсэн бөгөөд хүн бүхний хайрыг татсан бяцхан зурх билээ. 2021 оны 7-р сарын 8-ны тэр нэгэн өдөр биднийг хэлж ирдэггүй зовлон дордорт й буйдан дээрээс дагзаараа унаж, тархины тов артерийн судас тасарч, гавлын яс заадсаараа цуурсан оноштойгоор яаралтай мэс засалд орсон юм. Бяцхан биедээ ахадсан хүнд мэс заслын дараа тархины 50% буюу зүл тархи бүхэлдээ үхэжсэн гэсэн оноштойгоор ГССҮТ болон ЭХЭМҮ Говд хэвтэн эмчлүүлж байна. Хүү минь цаг хором бүрт амьдралын төлөө т. шалгарч болохгүй гэдгийг сануулах мэт. Анх ГССҮТ-овд оношлуулахад эмч нар хүүг минь 7 хоногоос илүү тэсэхгүй гэж хэлсэн нь бидэнд маш хүнд цохилт болсон. Гэтэл зоригт бяцхан хүү маань 2 сарын хугацаа ид үхэлтэй тэмцэлдсээр байна. 9-р сарын 7-ны өдрийн сүүлчийн зургаар үхэжсэн хэсэгт тэлэлт үүсч одоогоор тархины 70% нь үхэжсэн байдалтай байгаа тул мархалтай гэдэгтэй үлдсэн амьдралын шаардлага тулгарлаа. Хүний тархи нь дэлхий дээрх хамгийн өндөр зардалтай эмчилгээ хийгддэг бөгөөд 800-900 сая төгрөгийн эмчилгээний төлбөр үлдсэн үр гэдэгтэй байдаг байна. Энэ нь маш их мөнгө тул бид гэр бүл, хамаатан саднаараа дэмжээд ч хүч хурэхгүй тул сайхан сэтгэлт Монголын ард түмнээсээ тусламжийн гараа сунгахыг чин сэтгэлээсээ хүсч байгааг хүлээн авна уу. Олны хүч олонгүй далай гэдэгчлэн та энэхүү ахилдыг уншиж байгаа бол бага гэж санаагаа чилээлгүй боломж зороо туслаач гэж хичээнгүйлэн хүсье.

ХААН БАНК:
5005616268 Б.Баяртүшиг /Аав/

TDB
450027194 Б.Баяртүшиг /Аав/